

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ТЭТГЭВРИЙН АСУУДЛААР ХАМТРАН АЖИЛЛАХ
ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ХУУЛИЙН ТӨСӨӨР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ

Олон улсын гэрээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэгт “Олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төслөөр Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцүүлэг зохион байгуулахгүй.” гэж заасан.

Тус яам Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах хууль”-ийн төслийг олон нийтэд дараах байдлаар хэлэлцүүлсэн болно. Үүнд:

1. Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.2 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудас <https://mlsp.gov.mn/content/detail/3557> -д 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдөр байршуулж олон нийтэд танилцуулж, хэлэлцүүлсэн. Цахим хуудсанд санал авахаар байршуулахад 182 удаа хандалттай бөгөөд санал ирүүлээгүй болно.

2. Мөн Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.6.2-т заасны дагуу Орхон аймаг (Дэнж, Эрдэнэ, Даваат, Говил, Эрдэнэт-Ус баг)-т 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс 02 дугаар сарын 01-ний өдөр, мөн Хэнтий аймагт 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга нар иргэдтэй хийх уулзалтад тус тус хэлэлцүүлсэн бөгөөд санал ирээгүй болно.

1. <https://mlsp.gov.mn/> цахим хуудсанд байршуулсан тухай

Нүүр Яамны тухай ▾ Бодлого, чиглэл ▾ Мэдээ, мэдээлэл ▾ Хууль

Төрийн үйлчилгээ ▾ 11-11 төв 1212.MN

Санал авч байна 2024-12-23

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөлд санал авч байна

Монгол Улсын Засгийн газраас гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэдийн нийгмийн хамгааллын эрхийг хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэрийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийн "Хэлэлцээр соёрхон батлах тухай" хуулийн төслийг боловсрууллаа.

Уг хэлэлцээрээр хоёр улсын иргэд Монгол Улс болон Бүгд Найрамдах Казахстан Улсад ажилласан, шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн өндөр насны тэтгэвэр тогтоолгох, Монгол Улсын иргэд Бүгд Найрамдах Казахстан Улсаас хуримтлалын тэтгэврийг тогтоолгон авах харилцааг зохицуулсан.

Та бүхэн хуулийн төсөлтэй танилцан саналаа Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газарт mlkhfbaual@mlsp.gov.mn цахим шуудангаар ирүүлнэ үү

Хуулийн төсөл болон хуулийн төслийн танилцуулгыг хавсралт хэсгээс татаж авна уу.

Хавсралт файл

№	Гарчиг	Татах
1	Хуулийн төслийн танилцуулга	Татах
2	Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл	Татах

182 Хуваалцах: [f](#) [t](#)

2. Орхон, Хэнтий аймагт хэлэлцүүлсэн тухай



